

АЖ АХУЙН НЭГЖИЙН ИННОВАЦИЙН ОНЦЛОГ

Г.Жаргал*, Д.Моломжамц**

Хураангуй: Эдийн засаг нь өөрөө өөрийгөө хөгжүүлэх тогтолцоо болохын хувьд хөгжлийг хувьсган өөрчлөх байнгийн хөдөлгөөнд орших бөгөөд энэхүү хөдөлгөгч хүч нь инновацийг буй болгон, хөгжүүлэх явдалд юуны түрүүнд тулгуурлана. Инноваци нь шинжлэх ухааны ололтууд, тэргүүн туршлагыг ашигласны дүнд техник, технологи, хөдөлмөрийн зохион байгуулалт, менежментийн салбарт шинийг нэвтрүүлэх явдал юм. Уламжлалт ойлголтоор инноваци нь ашгийг хамгийн ихээр нэмэгдүүлэх, эдийн засгийн, нийгмийн, экологийн, шинжлэх ухаан техникийн болон бусад хүчин зүйлсийг их хэмжээгээр авахын тулд шинээр нэвтрүүлсэн зүйлийн эцсийн үр дүнгээр тодорхойлогдоно.

Тиймээс аж ахуйн нэгжийн инновацийн асуудал нь улс орны хөгжил, тэр дундаа үндэсний инновацийн тогтолцоонд чухал байр суурь эзэлнэ. Энэхүү өгүүлэлд аж ахуйн нэгжийн инновацийн онолын зарим асуудлыг авч үзсэн болно.

Түлхүүр үг: аж ахуйн нэгж, инноваци, шинэ технологи, патент, инновацийн тогтолцоо, ноу хау

Инновацийн үүсэл хөгжил, онолын асуудлууд

Инноваци гэдэг үгийн гарал үүслийг авч үзвэл “in nova” буюу шинээр сэдэх, санаачлах гэсэн утгатай латин үг юм. Одоо хэрэглэгдэж байгаа дээрх үгийн утга нэлээдгүй өргөн хүрээг хамрана. 19-р зууны дундуур ялангуяа Германы соёл судлаачдын бүтээлүүдэд “инноваци” хэмээх ойлголт анх орж ирсэн. Эхэндээ инноваци гэдэг нь нэг соёлын зарим нэг элементийг нөгөө талын соёлд нэвтрүүлэх утга санааг илэрхийлдэг байжээ. Ялангуяа тухайн үедээ Европ маягийн ахуй амьдрал, үйлдвэрлэлийг зохион байгуулах аргыг Ази, Африкийн нийгэмд нэвтрүүлэх гэсэн агуулгаар хэрэглэгддэг байв. 20-р зууны

*Ховд их сургууль, (E-mail) jargal_galaa@yahoo.com

**МУИС-ийн, Бизнесийн сургууль, (E-mail) molomjants01112@yahoo.com

эхээр Австрийн эрдэмтэн Й.Шумпетер, Оросын эрдэмтэн Н.Кондратьев нар “эдийн засгийн хөгжилд шинэчлэл, өөрчлөлт оруулах замаар хямралыг даван туулах хэрэгсэл...” гэсэн утгаар ашигласан нь үндсэн утгаа одоо хэр нь алдаагүй байна. Анхдагч судлаачид:

- Шинэ бүтээгдэхүүн нэвтрүүлэх;
- Үйлдвэрлэлийн шинэ арга барилыг эзэмших;
- Шинэ зах зээл нээх;
- Шинэ түүхий эд гарган авах;
- Үйлдвэрлэлийн салбаруудыг шинээр зохион байгуулах гэсэн төрлүүдээр ангилан авч үзжээ.

Инновацийн талаарх нилээд чухал тодорхойлолтуудаас авч үзвэл:

- “Инноваци бол бизнесийн зорилгоор үйлдвэрлэлийн хүчин зүйлийг шинжлэх ухаан, зохион байгуулалтын хувьд шинээр нэгтгэх явдал” Й.Шумпетер
- “Шинэ санаанаас зах зээл дээр борлуулж буй бэлэн бүтээгдэхүүн хүртэлх бүхэл бүтэн үйл явц” Я.Кук, П.Майерс нар
- “Шинэ ба шинэчилсэн бүтээгдэхүүнийг зах зээлд нэвтрүүлэх, технологийн процессийг боловсронгуй болгох, нийгмийн үйлчилгээг сайжруулах чиглэлээр явуулж буй үйл ажиллагааны эцсийн үр дүн” OECD 1993
- “Эрдэм шинжилгээний ажлын үр дүнг эцсийн бүтээгдэхүүн болгон зах зээл, үйлдвэрлэл, үйлчилгээнд нэвтрүүлэх цогц үйл ажиллагаа” Монгол улсын ШУТ-ийн тухай хууль, 2008
- “Шинэ мэдлэгийг баялаг болгон хувиргах цогц үйл явц” Монгол улсын Инновацийн тухай хууль, 2012


Инновацийн талаарх судлаач эрдэмтэд, олон улсын байгууллага, улс орнуудын хуулийн тодорхойлолт зэргээс үзвэл инноваци гэдэг нь “шинэчлэх” гэсэн санааг илэрхийлж байна. Аль ч тодорхойлолт, томъёоллоор инноваци бол шинэ санаа буюу боловсронгуй болгосон бүтээгдэхүүн, үйлчилгээний хэлбэрээр зах зээлд борлогдож буй бүтээлч үйл ажиллагааны, эсвэл практик үйл ажиллагаанд ашиглагдаж буй шинэ буюу боловсронгуй болгосон технологийн процессийн үр дүн болно. Тиймээс инноваци бол шинэ санаа бүтээлийг практикт хэрэглэн шинэ бүтээгдэхүүн, технологийн процессийг буй болгож байгаа нийгэм-технологийн ба эдийн засгийн үйл явц гэж ойлгож болно.

Шинэ санаа төрөхөөс эхлэн шинэ зүйлийг бүтээх, нэвтрүүлэх, ашиглах

бүх орчлыг “инновацийн амьдралын мөчлөг” гэж нэрлэдэг. Инновацийн үйл ажиллагаа нь логик дэс дараалал бүхий нэг хэлхээнд нэгдсэн олон арга хэмжээний биелэлт юм. Энэ хэлхээ холбоос, үе шат бүхэн өөрийн хөгжлийн зүй тогтол, утга агуулгатай байна. Шинжлэх ухааны эрэл хайлт, туршилт - зохион бүтээлтийн ажил, технологийн боловсруулалт, хөрөнгө оруулалт, санхүүжилт, үйлдвэрлэлт борлуулалтын бүхий л арга хэмжээ нь нэгдэж, зөвхөн нэг зорилго - шинийг бүтээхэд чиглэдэг.

Технологийн хөгжлийн даяаршил, инноваци, олон улсын хамтын ажиллагаа улам эрчимтэй хөгжихөд нөлөөлж буй гол хүчин зүйлс нь:

- Санхүүгийн даяаршсан зах зээл;
- Өсөн нэмэгдэж буй хурц ширүүн өрсөлдөөн ба даяаршил;
- Үндэстэн дамнасан корпорациудын цар хүрээний өсөлт;
- Интернет, нарийн мяндсан шугам, тусгай зориулалтын хиймэл дагуул зэрэг холбоо, харилцааны хэрэгслүүдийн хөгжил;
- Капитал болон эдийн засаг, шинжлэх ухаан технологийн мэдээллийн урсгалыг янз бүрийн бүс нутаг дах хүмүүн капиталын нөөцтэй хослуулах нь эрс өөрчлөлт, шинэчлэл-инновацийн үйл явцыг улам хурдасгах боломжийг буй болгож байна. (Зураг 1)



Инновацийг хэмжих үндсэн шалгуур нь:

- Шинжлэх ухаан, технологийн хувьд шинэлэг;
- Практикт хэрэгжихүйц;
- Хэрэглэгчийн эрэлтэд нийцэж, зах зээлд арилжаалагдах шинжтэй байх ёстой. Өөрөөр хэлбэл хэрэглэгчдийн тодорхой эрэлт хэрэгцээг хангаж байж чадахуйц шинэ бүтээгдэхүүн, эсвэл шинэ процесст

шингэж бүтээгдсэн шинэлэг санаа л “инноваци” болж байна. Зах зээлийн эдийн засгийн нөхцөлд инновацийн салшгүй нэг шалгуур нь үзүүлэлт нь худалдаалагдах буюу таваар болох шинж чанар юм.

Инновацийг шинэлэг байдлаар нь:

- *Суурь шинжтэй* - бүтээгдэхүүн, технологийн процесс бүхэлдээ шинэ, эсвэл тэдгээрийн зарим элементийн үүрэг, шинж чанарт өөрчлөлт орсон байвал
- *Сайжруулах шинжтэй* - бэлэн бүтээгдэхүүн, эсвэл ихээхэн хэмжээний боловсруулалт хийгдсэн, түүнчлэн үйлдвэрлэлийн шинэ аргыг, эсвэл үлэмж хэмжээгээр боловсронгуй болгосон аргыг нэвтрүүлэхтэй холбоотой
- *Хуурмаг шинжтэй* - тухайн бүтээгдэхүүн, үйлдвэрлэлийн процесст чанарын шинжтэй өөрчлөлт гаргаагүй, өнгө үзэмж төдий өөрчлөлттэй, бүтэц чанар, орц, найрлага, үнэ, өртөгт өөрчлөлт гараагүй гэх зэргээр ангилж үздэг.

Инновацийг шинэлэг байдлаар ангилахдаа түүний технологийн үзүүлэлт, зах зээлд эзэлж буй байр суурийг мөн харгалзан үзнэ. Технологийн үзүүлэлтийг харгалзан:

1. Бүтээгдэхүүний инноваци - Шинэ материал, хагас боловсруулсан бүтээгдэхүүн, зарчмын шинэ бүтээгдэхүүн гаргаж буй
2. Процессийн инноваци - Үйлдвэрлэлийн шинэ технологи, автоматчилалын илүү өндөр түвшинг хэрэглэх, шинэ технологит тохирсон үйлдвэрлэлийг зохион байгуулах гэж ангилна.
Зах зээлд хэр шинэ байна гэдгээр нь дэлхий дахинд, улс орны хэмжээнд, тухайн байгууллага, үйлдвэрт шинэ инноваци гэж ангилж болно.

Инновацийн иж бүрэн ангилал

- Инновацийг ерөнхийд нь технологийн, технологийн бус гэсэн хоёр хэсэгт хувааж болно.
- Технологийн инновацид-Шинжлэх ухаан, технологийн дэвшлийг тодорхойлж буй үйлдвэрлэлийн хэрэгсэл, арга технологийг хөндсөн бүх өөрчлөлт, шинэчлэлт багтана. Судлаачид, бизнес эрхлэгчдийн анхаарал технологийн инновацид төвлөрч байна. Технологийн инноваци нь бүтээгдэхүүн хийх аргыг сайжруулж, илүү боловсронгуй болгоход техникийн иноваци нь шинэ буюу сайжруулсан бүтээгдэхүүний

үйлдвэрлэлд өгөөжөө өгдөг.

- Технологийн бус инновацид зохион байгуулалт, удирдлага, эрх зүй нийгмийн экологийн шинжтэй шинэчлэлт өөрчлөлтүүд хамаарна. Удирдлага зохион байгуулалтын инноваци нь үйлдвэрлэл, бүтээгдэхүүний хувиарлалт, түгээлт, тээвэр, борлуулалт, хангамжын зүй зохистой зохион байгуулалтыг буй болгоно. Нийгмийн инноваци нь хөдөлмөрийн нөхцлийг сайжруулах, эрүүл мэнд, соёлын асуудлыг оновчтой шийдвэрлэх арга зам болдог. Ер нь инновацийн үйл явц нийгмийн агуулга ач холбогдолтой байдаг тул инновацийн үйл явцыг төлөвлөж удирдахдаа нийгмийн үр дагаварыг нь харгалзан үзэх шаардлагатай байдаг. Мэдээллийн инноваци нь мэдээллийн үнэн бодит хурдан шуурхай чанарыг нэмэгдүүлэх, шинжлэх ухаан, технологийн үйл ажиллагааны хүрээнд мэдээллийн зүй зохистой урсгалыг хангахад үр нөлөөгөө өгсөөр байна.

Инновацийн иж бүрэн ангилал

Ангиллын шинж	Бүлэглэл
Хэрэглэх салбараар	- удирдлага, зохион байгуулалт, нийгэм, аж үйлдвэрийн зэрэг
Инновацийн үндэс болсон шинжлэх ухаан, технологийн дэвшлийн үе шатуудаар	- шинжлэх ухааны, технологийн, техник-тоног төхөөрөмжийн, зохион бүтээлтийн, үйлдвэрлэлийн мэдээллийн
Эрчимжилтийн түвшингээр	- "давалгаа", тэгш, сул, өргөн хэмжээний
Хэрэгжих хурдаар	- түргэн, удаан, аажмаар өсөх, тэнцвэртэй, үсрэнгүй
Цар хүрээгээр	- тив дамжсан, үндэстэн хоорондын, бүс нутгийн, үндэсний, томоохон, дунд, жижиг
Үр дүнгийн түвшингээр	- өндөр, тогтвортой, нам
Үр нөлөөгөөр	- эдийн засгийн , нийгмийн, экологийн, интеграль
Хамрах хүрээгээр	- эдийн засгийн, улс төрийн, эрх зүйн, нийгмийн боловсролын
Үйлдвэрлэлийн хүчин зүйлсээр	- үйлдвэрлэлийн хэрэгслийн, хөдөлмөрийн зүйлсийн, хөдөлмөрийн үр дүнгийн, ажиллах хүчний
Зориулалтаар	- сайжруулах, нэмж өөрчлөх, оруулах, солих

Инновацийн бүлэглэл /үйлдвэрлэх хүчний хөгжилд үзүүлэх ач холбогдлоор/

1. Суурь шинжтэй, том бүтээл /Технологийн хувьсал-шинэ чиглэл,

чанарын өөрчлөлт-шинэ салбар/. Суурь инноваци нь урт хугацаа, зардал, хүч ихээр шаардагдах боловч далайц, түвшингээрээ эдийн засаг, нийгмийн ач холбогдол өндөртэй.

2. Ижил суурь дээр буй болсон зарчмын шинэ зэхэц /Технологийн нэг үе солигдоно-суурь зарчим дээр шинэ технологи/. Суурь зарчмын үндсэн дээр хавсарга судалгааны үр дүнд буй болсон технологи, шинэ бүтээгдэхүүн, техник хэрэгсэл нь эрэлт хэрэгцээг хангах чадвар бүхий үзүүлэлтүүдтэй байна. Ийм инновацийг хэрэгжүүлэх хугацаа богино, зардал бага боловч үр ашиг их бус байна.
3. Дунд түвшиний бүтээл ноу хау, шинэ загвар /технологийн шинэ, техникийн шинэчлэл, бүтээгдэхүүний шинэчлэл/. Дунд түвшиний бүтээл ноу хау шинжтэй, хосолмол шинэ бүтээлийн инноваци нь тухайн үед байгаа технологийг боловсронгуй болгох техникийг шинэчлэх, бүтээгдэхүүний техникийн болон хэрэглээний үзүүлэлтүүдийг сайжруулах боломж олгоно.
4. Бага зэргийн хосолмол шинж бүхий бүтээлүүд /Үндсэн үзүүлэлтүүд хэвээр, хоёрдогч паратетрүүд сайжирна/. Бага зэргийн хосолмол шинж бүхий шинэ бүтээлүүдийг багтаасан байдаг.

Инновацийн үйл явцын мөчлөг

Инновацийн үйл явцын мөчлөгийг дараах байдлаар ангилж авч үздэг.

1. Судалгааны мөчлөг. /шинжлэх ухааны суурь судалгаа, нээлт, бүтээл, практикт нэвтрүүлэх туршилт, шинэ бүтээгдэхүүн, процесс буй болгож, үйлдвэрлэлд нэвтрүүлэн зах зээлд худалдаалан хэрэгцээнд нийлүүлнэ/. Судалгааны мөчлөг нь харьцангуй урт хугацаа шаардах боловч суурь судалгааны хөгжил өндөр үр ашигтай инновацийн үндэс болдог, төрийн дэмжлэг чухал үүрэгтэй.
2. Худалдааны мөчлөг. /Бодит үр дүнд хүрэх богино хугацаа, хувийн сектороос хөрөнгө оруулах сонирхол/. Худалдааны мөчлөг нь мэдлэгийг хэрэглээний эргэлтэд оруулах механизмыг оновчтой бүрдүүлсэнээр инновацийг богино хугацаанд буй болгоно.

Инновацийн үйл явцын энгийн загвар

Суурь судалгаа-хавсарга судалгаа, технологи, маркетинг-туршилт, зохион бүтээлт, үйлдвэрлэлийн бэлтгэл-үйлдвэрлэл-борлуулалт

Инновацийн үйл явц дотроо хэрхэн яаж өрнөж байгааг логигоор ангилж үздэг хэд хэдэн загвар байдаг. Инноваци суурь судалгаанаас эхлээд тодорхой

шатуудыг дамжин бүтээгдэхүүнийг хэрэглэх хүрээнд дуусч байгааг энгийн загвар харуулж байна. Гэхдээ шинжлэх ухааны шинэ мэдлэг эдийн засгийн шууд өсөлтөнд шууд нөлөөлж байх ёстой. Энэ загварын сайн тал нь тун энгийн, сул тал нь салбар, хэсгүүд хоорондын цогц хэлхээ холбоо, эргэх холбооны механизмыг бүрэн илэрхийлээгүй, гадаад нөхцөл байдал, хүчин зүйлсийг тооцоогүйд оршино.

“Кибернетикийн хар хайрцаг” загвар

Шинэ санаа-оногтой үйл явц (хувиргагч)-чансаат бүтээгдэхүүн: Энэ загвар нь шинэ санаа, бүтээгдэхүүний чансаа, инновацийг хэрэгжүүлж буй нарийн технологи, өрсөлдөх чадварын мэдрэмж гэсэн 4 шинжийг тодорхойлж болох боломжийг олгодог.

Кибернетикт өргөнөөр хэрэглэдэг “хар хайрцаг”-ны аргаар эрдэмтэд инновацийн үйл явцыг загварчилжээ. Кибернетикийн загвар нь инновацийн үйл явцыг цогц систем болгон төсөөлж, дотор нь үйл явцын элементүүдээс өөх хоорондоо байнгын холбоо, шүтэлцээнд оршдог дэд систем үүсгэж байгаа ба энэ систем нь бас олон тооны эргэх холбоотой. Оролт буюу оюуны “шинэ санаа” нь шинжлэх ухааны үр дүн-патент, бүтээгдэхүүний загвар, зохион бүтээлтийн хийц, хоу хау, лиценц болно. Гаралт буюу “чансаат бүтээгдэхүүн” инновацийн эцсийн зорилго, хамгийн гол шалгуур юм.

Инновацийн үр дүнгийн илэрхийлэл:

Инновацийн үр дүн ямар нэг бүтээгдэхүүн, үйлчилгээ, шинэ технологи, процесс, урьдах нөхцөл байдлын сайжруулалт, салбар, компани болон бүтээгдэхүүний өрсөлдөх чадварыг илэрхийлдэг. Үйл явц (хувиргагч) нь шинэ санааг илүү сайн бүтээгдэхүүн болгоод зогсохгүй, эргэх холбооны мэдээлэлд тулгуурлан гаралтыг зохицуулах үүрэгтэй. Эргэх холбоо дараагийн үйлдлийг хийх бөгөөд бүтээгдэхүүний чансаа түүнээс хамаарна. “Хар хайрцаг” загварын тусламжтайгаар тухайн шинэ зүйл инноваци мөн эсэхийг, эдийн засаг, нийгэм болон үйл ажиллагааны бусад бүхий л салбарт нэвтрүүлэх боломжтой, эсэхийг, шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээ нь зах зээл дээр худалдаалагдах шинжтэй эсэхийн тодорхойлно.

Аж ахуйн нэгжийн инновацийн онцлог

Аж ахуйн нэгжийн инновацийн стратеги нь тухайн байгууллагын үйл ажиллагааны бүх хүрээг хамрах бөгөөд дараах чиглэлээр ангилагдана.

Үүнд:

- **Бүтээгдэхүүн, үйлчилгээний инноваци** — борлуулалтын чадавхийг эрс шинэчилж, зах зээлд эзлэх байр суурийг бэхжүүлэн үйлчлүүлэгчдийн хүрээг тэлснээр компани бие даан хараат бусаар үйл ажиллагаагаа эрхэлж, цаашид улам бэхжих нөхцлийг бүрдүүлнэ.
- **Технологийн инноваци** — энэ нь үйлдвэрлэлийн чадавхийг хөгжүүлэх үйл явц юм. Технологийн инноваци нь хөдөлмөрийн бүтээмжийн өсөлт, нөөцийн хэмнэлтэд чиглэж, ашгийг өсгөх, аюулгүй ажиллагааг хангах, мэдээллийн технологи нэвтрүүлэх, байгаль орчныг хамгаалах зэрэг арга хэмжээг хэрэгжүүлэх өргөн боломж олгоно.
- **Зохион байгуулалтын инноваци** — энэ нь үйлдвэрлэлийн удирдлага зохион байгуулалтыг сайжруулах үйл явц юм.
- **Нийгмийн инноваци** — энэ нь тухайн байгууллагын доторхи нийгмийн орчныг сайжруулах үйл явц юм. Өөрөөр хэлбэл ажиллагчдыг компанийн бодлого, зорилгыг хэрэгжүүлэхэд дайчилж, хамт олны болон нийгмийн өмнө хүлээсэн үүргүүдэд улам итгэлтэй болгоно.

Аж ахуйн нэгжийн инновацийн стратеги: Пүүс компаниуд ерөнхийдөө инновацийн стратегийн хоёр хэлбэр болох “хамгаалалтын стратеги”, эсвэл “давших стратеги” — ийг хэрэгжүүлдэг. Хамгаалалтын стратеги нь зах зээлд байр сууриа хэвээр хадгалах, бүтээгдэхүүний амьдралын мөчлөгийг тогтвортой байлгахад чиглэнэ. Энэ стратегийн хүрээнд хоёр гол асуудлыг тусгайлан авч үзнэ. Үүнд:

- Бүтээгдэхүүний амьдралын мөчлөгийг тогтвортой байлгах технологийн шийдлүүд
- Богино болон урт хугацааны өрсөлдөөний тогтолцооны үндэслэл, арга хэмжээ

Эдгээр нь үйлдвэрлэлийн процессийн уламжлал, тогтвортой байдалд нөлөөлдөг учраас нэг нь нөгөөгөө үгүйсгэж, бас нөхөн гүйцээдэг онцлогтой.

Инновацийн давших стратеги нь зах зээлд нэвтрэх зорилгоор технологийн шинэ шийдэл гаргахад чиглэнэ. Энэ стратеги нь бас хамгаалалтын шинжтэй, учир нь бүтээгдэхүүнийг хурдан шинэчилснээр компани зах зээл дээр байр сууриа хэвээр хадгалах боломжтой болдог. Том компаниуд инновацийн хоёр стратегийг хослуулан “хамгаалалт-давшил” гэсэн стратегийг хэрэгжүүлдэг байна.

Аж ахуйн нэгжийн үйлдвэрлэж буй бүтээгдэхүүний “амьдралын”

мөчлөг:

энэ нь дараах хэд хэдэн үе шатыг дамжин хэрэгждэг. Үүнд :

I үе шат — энэ шатанд эрдэм шинжилгээний бүтээлийг шинэ бүтээгдэхүүний загвар болгон хувиргах, зах зээлд дасгах, эдийн засгийн эргэлт оруулах нөхцлийг үнэлнэ. Түүнчлэн үйлдвэрлэлийн удирдлагын аппаратыг шинээр зохион байгуулах, эсвэл зохицуулан өөрчлөх ажлуудыг хийж гүйцэтгэнэ. Мөн туршилтын журмаар шинэ бүтээгдэхүүнийг борлуулж, холбогдох маркетингийн судалгааг хийдэг. Тиймээс бүтээгдэхүүний амьдралын мөчлөгийн эхний үе шат нь иж бүрэн шинж чанартай байна.

II үе шат — энэ шатанд үйлдвэрлэлийг тогтмолжуулж, борлуулалтыг нэмэгдүүлэн эдийн засгийн үр дүнг өсгөнө. Энэ үе шат нь материаллаг үйлдвэрлэл учраас бүтээгдэхүүний мөчлөгт маш чухал, чухам энд л үндсэн мөчлөгийн бодит суурь буй болдог.

III үе шат — энэ үе шатан дахь шинэ бүтээгдэхүүний цуврал үйлдвэрлэлийн хугацаа нь үр ашигт хоёр талын нөлөө үзүүлнэ. Нэг талаас, бүтээгдэхүүнийг удаан хугацаагаар үйлдвэрлэх нь эрэлтийг хангаж, нөхөн үйлдвэрлэлийн хуримтлал үүсгэнэ. Нөгөө талаас, хэрэглэгчийн сонирхлыг харгалзан бүтээгдэхүүнийг шинэчлэх нь зах зээлд байр сууриа хадгалах, өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх үндэс болдог. Тиймээс эдийн өсөлтийн хурдацтай уялдуулан бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн хугацааг оновчтой болгох шаардлагатай.


IV үе шат — Өмнөх шатны үр ашиг буурах нь зардлыг багасгах, эсвэл бүтээгдэхүүний хэрэглээний үзүүлэлтүүдийг дээшлүүлэхийг сануулсан дохио болдог. Тиймээс энэ шатанд ийм өөрчлөлт хийвэл мөчлөгийг уртасгах боломжтой байна.

V үе шат — Зах зээлд төсөөтэй шинэ бүтээгдэхүүн гарснаар өмнө байсан эрэлт буурч, борлуулалт, үр ашиг багасах нь “шинэ” байсан бүтээгдэхүүн хуучирсны шинж юм. Энэ бол зайлшгүй үзэгдэл бөгөөд үүгээр бүтээгдэхүүний амьдралын мөчлөг дуусна.

Аж ахуйн нэгжүүд шинэ бүтээгдэхүүнийг дараах байдлаар үйлдвэрлэж болно. Үүнд :

- Шинэ бүтээгдэхүүнийг цувралаар, өөрөөр хэлбэл хуучин, шинийг дараалан үйлдвэрлэж болно. (Зураг А)
- Хуучин болон шинийг зэрэг үйлдвэрлэж болно. (Зураг Б)
- Хуучин, шинэ бүтээгдэхүүнийг зэрэгцүүлэн цувралаар үйлдвэрлэж

болно. (Зураг В) Эдгээрийг дараах зургаар үзүүлэв.



Дүгнэлт

Аж ахуйн нэгжийн инноваци бол үндэсний инновацийн тогтолцооны нэг чухал бүрэлдэхүүн хэсэг юм. Тиймээс аж ахуйн нэгжид инновацийн нэвтрүүлэхдээ онол арга зүйн талаас нь нухацтай судалсны үндсэн дээр тодорхой хөтөлбөр, дэс дараалал зэргийг баримтлан үе шаттайгаар хэрэгжүүлэх ёстой. Учир аж ахуйн нэгжүүдийн удаан хугацааны тогтвортой, үр ашиг бүхий үйл ажиллагаа нь улс орны эдийн засгийн хөгжлийн үндэс суурь болж байдагтай холбоотой. Харин аж ахуйн нэгжийн оршин тогтнох, зах зээлд амжилттай өрсөлдөх, өргөжин тэлэх үндэс суурь нь инновацийг нэвтрүүлэх, түүний үр ашгийг дээшлүүлэх явдал болно.

Ашигласан материал

- Lundvall B.-A., National systems of innovation. Towards a theory of innovation and interactive learning, London: Pinter publishers, 1992
 В.И.Аверченков, Е.Е.Ваинмаер., Инновацийг удирдахуй, Улаанбаатар, 2014 (орч. Д.Авирмэд)
 О.С.Белокрыловой., Теория инновационной экономики, Ростов, 2009